



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 07 одер

Дугаар A/336

Мандалговь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн A/214 дугаар тушаалын дагуу 2021 оны 09 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд Адаацаг, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Луус, Өлзийт, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Эрдэнэдалай сумдын үхэр болон бог малыг гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов хүргэж, зарлан мэдээллэж ажиллахыг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

2. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, шуурхай үр дүнтэй хэрэгжүүлэхийг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), захирамжийн хэрэгжилтийг ханггуулж тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очирт)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР



481210346